



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/325

Мандалговь

Ойн зурвас хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9, Нэгжийн тухай хуулийн 66.1, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 тоот тушаалын хавсралтаар баталсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам"-ын 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын 2022 онд байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээнд тусгагдсан ойжуулалт, ойн зурвас байгуулах ажлын хүрээнд Говь-Угтаал суманд 1 га, Өлзийт, Дэлгэрхангай сумдад тус бүр 2 га нийт 5 га талбайд хийгдсэн ойн зурвасын ажлын гүйцэтгэлийг шалган хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Гантулга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүд: М.Ганчимэг (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Цэрэнсугир (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

П.Уртнасан (Сум дундын ойн ангийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Золбоо (Сум дундын ойн ангийн мэргэжилтэн)

2. Ойжуулалт, ойн зурваст тарьж ургуулсан тарьц, суулгацын насжилтын хувь хэмжээг тогтоож, акт, танилцуулгыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны дотор холбогдох газруудад хүргүүлэхийг ажлын хэсэг (Н.Гантулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111244